



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Энэхүү тогтоолын хавсралтад заасан 1 /нэг/ хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээг шинэчлэн байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2024 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн
48... тоот тогтоолын
Хавсралт

Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн этгээдийн жагсаалт

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Үйлчилгээний хүртээмж, Хамрах хүрээ	Тусгай зөвшөөрлийн Хугацаа	Оруулах нэмэлт, өөрчлөлт
1	Монвсат нэтворк ХХК	12900338	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт "Арилжааны радио телевизийн үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрөл	2027.02.27	Хамрах хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт болгох.